# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 07 дугаар сарын 16
№26 (1322)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | |
|---|---|---|
| 417. | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай | 2139 |
| 418. | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай | 2185 |
| 419. | Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2187 |
| 420. | Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2191 |
| 421. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2193 |
| 422. | Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2195 |
| 423. | Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2196 |
| 424. | Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2197 |
| 425. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2199 |
| 426. | Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2203 |

| | | |
|---|---|---|
| 427. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2206 |
| 428. | Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2207 |
| 429. | Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2208 |
| 430. | Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 2209 |
| 431. | Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай | 2210 |
| 432. | Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2211 |
| 433. | Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 2212 |
| 434. | Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2214 |
| 435. | Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай /Шинэчилсэн найруулга/ | 2216 |
| 436. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2243 |
| 437. | Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2244 |
| 438. | Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 2245 |

| | | | |
|---|---|---|---|
| 439. | Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 2246 |
| 440. | Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | | 2248 |


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 441. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 36 | 2249 |
| 442. | Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай | Дугаар 01 | 2250 |
| 443. | Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай | Дугаар 02 | 2253 |

[illegible]

Moehgoe Folo_ oa Heol I

| | | |
|---|---|---|
| [illegible] | ᠴᠡᠷᠢᠭ ᠦᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠬᠠᠭᠠᠭᠴᠢ ᠶᠢᠨ [illegible] ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | [illegible] |
| [illegible] | ᠴᠡᠷᠢᠭ ᠦᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | [illegible] |
| [illegible] | ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠡᠪᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ | [illegible] |
| [illegible] | [illegible] /ᠠᠯᠪᠠᠨ ᠪᠤᠰᠤ ᠣᠷᠴᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ/ | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |
| [illegible] | [illegible] | [illegible] |

| | | | |
|---|---|---|---|
| ᠑᠑᠓᠂ | ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ [illegible] ᠲᠤᠬᠠᠢ | ᠳᠤᠭᠠᠷ ᠐᠙ | ᠒᠒᠕᠓ |
| ᠑᠑᠒᠂ | ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ [illegible] ᠲᠤᠬᠠᠢ | ᠳᠤᠭᠠᠷ ᠐᠗ | ᠒᠒᠕᠐ |
| ᠑᠑᠗᠂ | [illegible] ᠲᠤᠬᠠᠢ | ᠳᠤᠭᠠᠷ ᠓᠖ | ᠒᠒᠑᠗ |
| | **Moehgo& Folo_ oa YekEt Hore& oa Doeedege&** | | |
| ᠑᠑᠐᠂ | [illegible] ᠲᠤᠬᠠᠢ | | ᠒᠒᠑᠘ |
| ᠑᠓᠗᠂ | [illegible] ᠲᠤᠬᠠᠢ | | ᠒᠒᠑᠖ |

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр | Улаанбаатар хот

## СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж**

2.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Соёлын тухай хууль[2], энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэхтэй холбогдсон харилцаанд үйлчилнэ.

3.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар энэ хуульд зааснаас илүү тааламжтай нөхцөлийг бусад хуулиар олгож байгаа бол тухайн хуулийн зохицуулалтыг баримтална.

**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэж Соёлын тухай хуулийн 3.1.6-д заасныг;

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.
[2] Соёлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2021 оны 32 дугаарт нийтлэгдсэн.

4.1.2.“соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч” гэж соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг;

4.1.3.“соёлын бүтээгдэхүүн” гэж Соёлын тухай хуулийн 3.1.4-т заасныг;

4.1.4.“соёлын үйлчилгээ” гэж Соёлын тухай хуулийн 3.1.5-д заасныг;

4.1.5.“соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц” гэж соёлын бүтээлч үйлдвэрлэлд хөрөнгө, нөөцийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий барилга байгууламж, бусад зохион байгуулалтын бүтцийг;

4.1.6.“соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк” гэж тодорхой зорилтыг хэрэгжүүлэх тусгайлсан нутаг дэвсгэр, дэд бүтцийн хангамж болон бизнесийн таатай орчин бүхий үйл ажиллагаагаар харилцан уялдсан цогцолборыг;

4.1.7.“соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор” гэж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тодорхой чиглэлийн дэд бүтцийн хангамж, бизнесийн таатай орчин, зохион байгуулалт бүхий байгууламжийг;

4.1.8.“соёлын бүтээлч үйлдвэрлэлийн кластер” гэж газар зүйн байршлын хувьд болон нэмүү өртөг бий болгох боломжтой зорилго, үйл ажиллагаагаар хорших, төрөлжих хэлбэрээр нэгдсэн зохион байгуулалтад орж хамтран ажиллахыг;

4.1.9.“соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс” гэж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, судалгаа шинжилгээ хийх, хүний нөөцийг бэлтгэх, хамтарсан үйлдвэрлэл явуулах зэргээр энэ хуулийн 4.1.8-д заасан кластер байгуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч хүн, хуулийн этгээд, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагын төвлөрсөн байршил, орон зайг.

**5 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилго**

5.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих зорилго нь соёлын бүтээлч үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжиж, үндэсний эдийн засгийн өсөлтөд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

**6 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжихэд баримтлах зарчим**

6.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжихэд дараах зарчмыг баримтална:

6.1.1.нийгмийн түншлэл, иргэдийн оролцоог дэмжсэн байх;

6.1.2.орон нутгийн өвөрмөц онцлог, чадавхад үндэслэсэн байх;

6.1.3.хөдөлмөр эрхлэлт, өрсөлдөх чадварыг дэмжсэн байх;

6.1.4.байгаль орчинд ээлтэй байх;

6.1.5.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, дэвшилтэт технологи, инновацад тулгуурласан байх;

6.1.6.аялал жуулчлалыг дэмжсэн, эдийн засгийн үр ашигтай байх;

6.1.7.салбар хоорондын уялдааг хангасан байх;

6.1.8.ил тод, нээлттэй, тэгш, хүртээмжтэй байх.

**7 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамрах хүрээ, чиглэл**

7.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлд технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүтээх, үйлдвэрлэх, түгээхтэй холбоотой үйл ажиллагааг хамааруулна.

7.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлно:

7.2.1.хөгжим, тайзны урлаг, гүйцэтгэн тоглох урлагтай холбоотой бусад салбар;

7.2.2.кино, дэлгэцийн урлаг, дижитал контент, тоглоом хөгжүүлэлттэй холбоотой салбар;

7.2.3.дүрслэх урлаг, архитектур, дизайн, хувцас загвар, гар урлалтай холбоотой салбар;

7.2.4.утга зохиол, ном, хэвлэлтэй холбоотой салбар;

7.2.5.соёлын өв, соёлын үнэт зүйлтэй холбоотой болон бүтээлч орон зай, чөлөөт цагийн үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой салбар.

7.3.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамрах хүрээг Соёлын тухай хуулийн 9.1-д заасан үйл ажиллагааны чиглэлтэй нийцүүлэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүтээх, үйлдвэрлэх, түгээх үйл явцтай уялдуулан нарийвчлан тодорхойлно.

7.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хамрах хүрээ, үндсэн чиглэлийг энэ хуулийн 7.3-т заасны дагуу Засгийн газар тогтооно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ТӨРӨӨС ДЭМЖИХ

**8 дугаар зүйл.Үндэсний соёлын агуулгын дэмжлэг**

8.1.Төрөөс үндэсний соёлын агуулгыг судлах, хөгжүүлэх, хадгалах, түгээн дэлгэрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

8.2.Үндэсний соёлын агуулгыг түгээх, таниулах болон соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын иргэнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг төрөөс үнэ төлбөргүй олгоно.

8.3.Энэ хуулийн 8.2-т заасан соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг 16-18 насны иргэнд жил бүр олгоно.

8.4.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан үндэсний соёлын агуулгыг дэмжих, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох, хянах, хэрэглэгчийн статистик мэдээлэлд үндэслэн хязгаарлалт тогтоохтой холбоотой журам болон эрхийн бичгийн санхүүжилтийн хэмжээг Засгийн газар батална.

8.5.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд үндэсний соёлын агуулгыг дэмжих зохицуулалтыг Монгол Улсын олон улсын гэрээний хүрээнд хийж болно.

**9 дүгээр зүйл.Хүний нөөцийн хөгжлийн дэмжлэг**

9.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарт мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх сургалт-үйлдвэрлэлийн уялдааг хангасан тогтолцоог мэргэшлийн үндэсний хүрээнд тулгуурлан хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, төлөвлөгөөг соёлын, боловсрол, шинжлэх ухааны, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ.

9.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн мэргэжилтэн, хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

9.3.Энэ хуулийн 9.1, 9.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллага, боловсролын байгууллага, ажил олгогчдын хамтын ажиллагаанд тулгуурлана.

9.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн эрэлттэй мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэхэд гарсан зардлыг бүрэн болон хэсэгчлэн олгоно.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батална.

9.6.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.6.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын тэтгэлэг, зээл олгох ажлыг зохион байгуулах;

9.6.2.Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт, Засгийн газар хоорондын гэрээний дагуу гадаад улсад тэтгэлгээр сургах хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлд энэ хуулийн 7.3-т заасан чиглэлийн мэргэжлийг хамруулах арга хэмжээг боловсролын хууль тогтоомжид нийцүүлэн авах;

9.6.3.бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт иргэний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, оюуны өмчийн боловсрол олгох агуулгыг тусгах;

9.6.4.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа дээд боловсролын сургалтын байгууллагын эрдэм шинжилгээ, инновацын чадавхыг бэхжүүлэх, судалгаа, хөгжүүлэлтийн ажилд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.

9.7.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

9.7.1.мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, дагалдан сургах, ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах, мэргэжлийн ур чадварын тэмцээн, уралдаан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

9.7.2.соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг туршлага солилцох, гадаад улсад дадлагажих, гадаад ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

9.7.3.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолтыг олон улсын аргачлалаар боловсруулах, холбогдох хуульд заасны дагуу батлуулах.

9.8.Энэ хуулийн 9.6.1, 9.6.4-т заасан дэмжлэгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Боловсролын зээлийн сангийн хөрөнгөөр, энэ хуулийн 9.7.1, 9.7.2-т заасан дэмжлэгийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгөөр тус тус санхүүжүүлнэ.

**10 дугаар зүйл.Технологийн судалгаа, хөгжүүлэлтийн дэмжлэг**

10.1.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүтээх, үйлдвэрлэхэд шаардлагатай технологийг шинээр нэвтрүүлэх, дамжуулах, хөгжүүлэх төсөлд дэмжлэг үзүүлнэ.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан дэмжлэгийг үзүүлэхэд өндөр бүтээмжтэй, салбарын инновацын чадавхыг нэмэгдүүлэх, эсхүл олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх байдлыг харгалзан үзнэ.

10.3.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн технологийн судалгаа, хөгжүүлэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу татварын дэмжлэгийг үзүүлнэ.

**11 дүгээр зүйл.Судалгаа, хөгжүүлэлтийн дэмжлэг**

11.1.Төрөөс соёлын бүтээлч үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлтэд дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ:

11.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлтийн төсөл, хөтөлбөрийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээнд хамруулах;

11.1.2.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлтийн төсөл, хөтөлбөрт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлэх;

11.1.3.соёлын бүтээлч үйлдвэрлэлд нэвтрүүлэх, нутагшуулах стандартыг боловсруулан батлуулахад дэмжлэг үзүүлэх;

11.1.4.энэ хуулийн 10 дугаар зүйлд зааснаас бусад соёлын бүтээлч үйлдвэрлэлийн судалгаа, хөгжүүлэлтэд зарцуулах зардлын тодорхой хэсгийг, эсхүл зарцуулсан зардлын тодорхой хувийг нөхөн олгож санхүүжүүлэх;

11.1.5.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бодлого, статистик, инновац, оюуны өмчийн үнэлгээ, технологийн судалгаа, хөгжүүлэлтийн суурь болон хавсарга судалгааг гэрээний үндсэн дээр дээд боловсролын сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх.

11.2.Энэ хуулийн 10.1, 11.1-д заасан судалгаа, хөгжүүлэлтийн шалгуур тогтоох аргачлал, зарцуулсан зардлын тодорхой хувийг буцаан олгох болон судалгааны байгууллагын үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

**12 дугаар зүйл.Оюуны өмчийн хамгаалалтын дэмжлэг**

12.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

12.1.1.оюуны өмчийн эрхийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, эрхийн зөрчилгүй соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг дэмжих чиглэлээр соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

12.1.2.соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах;

12.1.3.соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн оюуны өмчийг бүртгэх, хамгаалах, олон улсын эрхийн хамгаалалтын хүсэлт гаргахад дэмжлэг үзүүлэх;

12.1.4.соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг хууль бусаар хуулбарлах, түгээхээс урьдчилан сэргийлэх;

12.1.5.оюуны өмчийн эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой санал боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх, дэмжлэг үзүүлэх;

12.1.6.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон оюуны өмчид үнэлгээ хийх, зах зээлд сурталчлан таниулах, хөрөнгө оруулалт татах.

12.2.Төсвийн санхүүжилтээр бий болсон оюуны өмчийг холбогдох журмын дагуу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх бөгөөд уг бүтээлийг ашиглах онцгой эрхийг соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид хөнгөлөлттэй нөхцөлөөр бүрэн болон хэсэгчлэн ашиглуулж, ил тод мэдээлнэ.

12.3.Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдол бүрийг бүртгэх, хянах систем, дэд бүтэцтэй байна. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас соёлын бүтээгдэхүүний төрөл, уялдааг харгалзан дэд бүтэц, системийг нэвтрүүлнэ.

12.4.Энэ хуулийн 12.2, 12.3-т заасан тодорхой нөхцөл, системийн мэдээллийг бүрдүүлэх этгээдэд тавих шалгуур, дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

12.5.Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах этгээд нь хамтын удирдлагын байгууллага, эсхүл эрх эзэмшигчтэй бүтээл ашиглах гэрээ байгуулж, энэ хуулийн 12.3-т заасан систем, дэд бүтцэд холбогдсон байна.

12.6.Энэ хуулийн 12.3-т заасан систем хөгжүүлэлтийг гүйцэтгэх этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн[3] дагуу шалгаруулна.

12.7.Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдол бүрийг бүртгэх, хянах системийн мэдээллийг бүрдүүлэх, хэрэглэх чиг үүргийг хамтын удирдлагын байгууллага, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан үндсэн чиглэл тус бүрийн мэргэжлийн нэгдсэн холбоо гүйцэтгэж болно. Холбогдох этгээдийг энэ хуулийн 12.4-т заасан шалгуурын дагуу сонгох, санхүүжүүлэх, хяналт тавих чиг үүргийг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

12.8.Энэ хуулийн 12.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллага нь Оюуны өмчийн тухай хуулийн[4] 17.2-т заасан объектын төрөл тус бүрийн зохиогчийн эрх эзэмшигчийн олонхыг нэгтгэсэн байна.

12.9.Энэ хуулийн 12.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд гэрээ байгуулах, цуцлах арга хэмжээг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна.

12.10.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 12.3, 12.5, 12.7-д заасан чиг үүргийг бусад төрийн байгууллага, хуулийн этгээдэд шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

12.11.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага нь хамтын удирдлагын байгууллагын энэ хуулийн 12.4-т зааснаас бусад үйл ажиллагаанд санхүүжилт олгож болно.

### 13 дугаар зүйл.Төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хөнгөлөлттэй зээлийн болон бусад дэмжлэг

[3] Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 35 дугаарт нийтлэгдсэн.
[4] Оюуны өмчийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

13.1.Төсөв, хөрөнгө оруулалт, санхүүжилт, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгийг дараах хэлбэрээр үзүүлж болно:

13.1.1.төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

13.1.2.хөрөнгө оруулалт, санхүүжилт, зээл олгох, зээлийн батлан даалт гаргах;

13.1.3.Засгийн газрын баталгаа гаргах;

13.1.4.төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хэсгийг санхүүжүүлэх;

13.1.5.татварын дэмжлэг үзүүлэх;

13.1.6.төслийн санхүүжилтэд санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх;

13.1.7.бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх.

13.2.Энэ хуулийн 13.1.3-т заасан Засгийн газрын баталгаа дараах төрөлтэй байж болно:

13.2.1.өрийн баталгаа;

13.2.2.олох орлогын хамгийн доод хэмжээнд баталгаа гаргах;

13.2.3.үйл ажиллагааны тогтвортой байдлын баталгаа;

13.2.4.төрийн байгууллагаас зөвшөөрөл, дэмжлэг үзүүлэх баталгаа;

13.2.5.Хөрөнгө оруулалтын тухай хуульд[5] заасан татварын болон татварын бус дэмжлэг.

13.3.Энэ хуулийн 13.1-д заасан дэмжлэгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үзүүлнэ.

**14 дүгээр зүйл.Мэдээлэл солилцох, олон улсын зах зээлд нэвтрэхэд үзүүлэх дэмжлэг**

14.1.Энэ хуулийн 7.4-т заасан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндсэн чиглэлийн хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг олон улсын зах зээлд нэвтрэхэд соёлын болон холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас дараах бодлогын болон санхүүгийн дэмжлэгийг үзүүлнэ:

14.1.1.маркетингийн сурталчилгааны үйл ажиллагааг дэмжих, олон улс, бүс нутгийн түвшинд маркетингийн үйл ажиллагаа

[5] Хөрөнгө оруулалтын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2013 оны 41 дугаарт нийтлэгдсэн.

эрхэлдэг байгууллага, продюсертэй хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх;

14.1.2.олон улсын арга хэмжээ, худалдааны үзэсгэлэнд оролцуулах, олон улсын арга хэмжээг Монгол Улсад зохион байгуулах;

14.1.3.олон улсын зорилтот зах зээлийн судалгаа хийх, үндэсний соёлын агуулга бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

14.2.Энэ хуулийн 14.1, 14.5-д заасан арга хэмжээний жагсаалт, дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

14.3.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүртгэл, мэдээллийн сантай байна.

14.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүртгэл, мэдээллийн санг цахим хэлбэрт оруулах, мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн төрлийг тодорхойлох, ашиглах, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах журмыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хөгжил, харилцаа холбооны болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

14.5.Төрөөс соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг түгээх платформ бий болгох, түгээлтийн олон улсын сүлжээнд холбогдох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

14.6.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн статистик мэдээллийг олон улсын аргачлалаар бүрдүүлэх, мэдээллийн сан үүсгэх, соёлын статистикийн тогтолцоог хөгжүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

### 15 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн нийгмийн түншлэлийг хэрэгжүүлэх

15.1.Засгийн газрын шийдвэрээр соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг мэргэжлийн байгууллага, хамтын удирдлагын байгууллага, эсхүл хувийн хэвшлийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

15.2.Хуулиар хориглоогүй, оюуны өмчийн эрхийг зөрчихгүй бол холбогдох шийдвэрийн үндсэн дээр төрийн хамгаалалтад байдаг соёлын үнэт зүйлийн загварыг бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, бүтээх, үйлдвэрлэх, түгээхэд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид төлбөртэйгээр ашиглуулж болно. Энэ тохиолдолд тухайн соёлын үнэт зүйлийг хадгалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага бүртгэл хийж, олон нийтэд мэдээлнэ.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасны дагуу ашиглахад Соёлын тухай хуулийн 35 дугаар зүйлийг баримтална.

15.4.Соёлын тухай хуулийн 35.3-т зааснаас бусад соёлын үнэт зүйлийн загвараар бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, бүтээх, үйлдвэрлэх, түгээх, ашиглуулах тохиолдолд тухайн соёлын үнэт зүйлийг эзэмших, ашиглах чиг үүрэг бүхий төрийн байгууллага холбогдох хууль тогтоомж болон Иргэний хуулийн[6] $338^1$ дүгээр зүйлийн дагуу гэрээ байгуулж ашиглуулна.

15.5.Энэ хуулийн 15.4-т заасан эрх бүхий байгууллага соёлын үнэт зүйлийн загварыг ашиглуулснаас бий болсон орлогын тодорхой хувийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн[7] 5.3.13-т заасан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих санд төвлөрүүлж, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ, инновац, технологийн судалгаа, хөгжүүлэлт, бизнесийн зөвлөх үйлчилгээ, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх сургалтад зарцуулна.

15.6.Соёлын үнэт зүйлийн загварыг арилжааны бус зорилгоор ашиглах бол эрх бүхий байгууллага соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид хөнгөлөлттэй үнэ санал болгож болно.

15.7.Энэ хуулийн 15.4-т заасны дагуу ашиглах журам болон 15.6-д заасан хөнгөлөлт үзүүлэх нөхцөл, журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

15.8.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр соёлын бүтээлч үйлдвэрлэлд хамаарах төсөл хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

15.9.Холбогдох төрийн байгууллага соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл өгөх, гадаад ажилтны тоог нэмэгдүүлэх, гадаад ажилтны ажлын байрны төлбөрийн талаарх лавлагаа, тодорхойлолтыг гаргаж үйлчилнэ.

[6] Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.
[7] Засгийн газрын тусгай сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

**16 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтцийг нэмэгдүүлэх, ашиглуулах**

16.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх төлөвлөлтийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгах, хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын дагуу эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан зайлшгүй шаардлагатай соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтцийг барих, ашиглах зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

16.3.Төрийн эзэмшлийн дэд бүтцийн байгууламжийг соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид гэрээний үндсэн дээр ашиглуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

16.4.Шинээр барьж байгуулах чөлөөт бүс, хилийн боомт, нисэх онгоцны болон галт тэрэгний буудал, хот, суурин газрын төлөвлөлтөд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтцийн төлөвлөлтийг тусгасан байна.

16.5.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтцийг барих, түүнд хөрөнгө оруулалт хийсэн хүн, хуулийн этгээдэд холбогдох хуулийн хүрээнд татварын дэмжлэг үзүүлнэ.

**17 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх зохион байгуулалтын хэлбэр**

17.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг зохион байгуулалтын хувьд дараах хэлбэрээр хөгжүүлнэ:

17.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн кластер, парк, цогцолбор, инкубатор байгуулахад дэмжлэг үзүүлэх;

17.1.2.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих бүс тогтоох, дэд бүтцийн хангамжийг сайжруулах;

17.1.3.үйл ажиллагаагаараа хорших, төрөлжих, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, экосистем, бүтээлч орон зайг бий болгох.

17.2.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк, цогцолбор байгуулах саналыг техник, эдийн засгийн үндэслэлийн хамт Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасан төрөөс санхүүжүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк, цогцолборыг дараах зорилгоор байгуулна:

17.3.1.үндэсний соёлын агуулга бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

17.3.2.импортыг орлох соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүтээх, үйлдвэрлэлийг дэмжих;

17.3.3.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн инновацын чадавх, технологийн түвшнийг нэмэгдүүлэх судалгаа, хөгжүүлэлтийг дэмжих;

17.3.4.соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид инкубатораар дамжуулан бизнес, технологийн зөвлөх үйлчилгээг үзүүлэх.

17.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэхэд дараах тохиолдолд бодлого, татвар, санхүүгийн цогц дэмжлэгийг үзүүлнэ:

17.4.1.орон нутгийн онцлогоос хамаарч соёлын өв, эдийн засаг, дэд бүтцэд нь тохирсон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн кластер;

17.4.2.олон улсын зах зээлд өрсөлдөх үндэсний соёлын агуулга бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээний нэмүү өртгийн сүлжээ бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийн кластер.

17.5.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн кластерын төлөвлөлт, эсхүл техник, эдийн засгийн үндэслэлийг үндэслэн дараах дэмжлэгийг үзүүлнэ:

17.5.1.дэд бүтцийн хангамжийг сайжруулах;

17.5.2.үйл ажиллагаагаараа хорших, төрөлжих, хамтран ажиллахад нь бизнесийн болон технологийн зөвлөх үйлчилгээг үзүүлэх;

17.5.3.хүний нөөц бүрдүүлэх, мэргэшүүлэхэд дэмжих;

17.5.4.хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх;

17.5.5.олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах;

17.5.6.бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, борлуулалтын сувгийг бүрдүүлэх.

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан дэмжлэгийг хүссэн этгээд нь техник, эдийн засгийн үндэслэлээ соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

17.7.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн инкубаторыг их, дээд сургууль, мэргэжлийн холбоо, хувийн хэвшлийн санаачилгаар байгуулахад төрөөс дараах дэмжлэгийг үзүүлнэ:

17.7.1.санхүүгийн дэмжлэг;

17.7.2.үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай дэд бүтцийн хангамж;

17.7.3.хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл олгох, татварын хөнгөлөлт;

17.7.4.төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх.

17.8.Энэ хуулийн 17.3, 17.4, 17.5, 17.6, 17.7-д заасан асуудлаар төсөл сонгон шалгаруулалт зарлах болон төслийн саналыг дүгнэсний үндсэн дээр санхүүжүүлэх, нэгдсэн бодлогоор хангах арга хэмжээг Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга хэрэгжүүлэх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

17.9.Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд өөрийн онцлог, дэд бүтэц, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн төвлөрлийг харгалзан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх тодорхой байршил, орон зайг тогтоон, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан төлөвлөлтийг хийж, дэмжлэг үзүүлнэ.

**18 дугаар зүйл.Үндэсний соёлын агуулга, үнэт зүйлийг илэрхийлэн таниулах орчныг бүрдүүлэх**

18.1.Хот төлөвлөлт, суурин газар, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, хөтөлбөр, ерөнхий төлөвлөгөө болон шинэ хороолол, барилга байгууламж төлөвлөх, барихад үндэсний соёлын онцлогийг тусгах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжсэн орон зайг Соёлын тухай хуулийн 30 дугаар зүйл болон холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хэрэгжүүлнэ.

18.2.Хүн, хуулийн этгээд, сууц өмчлөгчдийн холбоо нь оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж байгаа газрын байршил, эсхүл байр, орон сууцны тодорхой хэсэгт үндэсний соёлын онцлогийг харуулсан, иргэдэд чөлөөт цагаа өнгөрүүлэх, соёлын боловсрол эзэмших бүтээлч орон зай, бүтээлч дүр, төрхийг бий болгоно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

**19 дүгээр зүйл.Бүртгэл**

19.1.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ болон түүнийг бүтээх, үйлдвэрлэх, түгээх, ашиглах үйл явцыг бүртгэхэд олон улсын стандарт, ангиллыг баримтална. Олон улсын стандарт, ангиллыг нэвтрүүлж, мөрдөх үйл ажиллагааг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

19.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүртгэж, тодорхойлолт олгох бөгөөд соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох журмыг батална. Хуулийн этгээдийн улсын бүртгэл, эсхүл татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн болон шаардлагатай бусад мэдээлэл, журамд үндэслэн бүртгэх, бүртгэлээс хасах арга хэмжээ авна.

19.3.Соёлын бүтээлч үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэгийг энэ хуулийн 19.2-т заасан этгээдэд үзүүлнэ.

**20 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг**

20.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч дараах эрх эдэлнэ:

20.1.1.энэ хууль, бусад хууль тогтоомжид заасан дэмжлэг авах;

20.1.2.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэрийн төсөлд санал өгөх;

20.1.3.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортлох, зах зээлийн үнээр борлуулах;

20.1.4.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу газар эзэмших, ашиглах, дэд бүтцээр хангагдах;

20.1.5.оюуны өмчийн бүтээлээ ашиглах, үр шимийг хүртэх, оюуны өмчийн эрхээ хамгаалуулах, эрхийн шимтгэлийн орлого авах;

20.1.6.мэдээллийн сангаас өөрт хамаарах мэдээллийг авах, мэдээллээ шинэчлэх.

20.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч дараах үүрэг хүлээнэ:

20.2.1.хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, дүгнэлт, зөвлөмжийг биелүүлэх;

20.2.2.шударгаар өрсөлдөх;

20.2.3.соёлын бүтээлч үйлдвэрлэлтэй холбоотой хэрэглэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

20.2.4.хүний нөөцийн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх;

20.2.5.энэ хуулийн дагуу авсан дэмжлэгийг зориулалтын дагуу ашиглах, ашиглалтын явц, үр дүнг холбогдох эрх бүхий этгээдэд тайлагнах;

20.2.6.мэдээллийн санд мэдээлэл оруулах, үнэн зөв байдлыг хангах, хууль, журамд заасан хугацаанд хүргүүлэх;

20.2.7.оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байх.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

**21 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

21.1.Засгийн газар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

21.1.2.энэ хуульд заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх;

21.1.3.соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

21.1.4.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дотоодын зах зээлийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх;

21.1.5.Монгол Улсад бүтээгдсэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг дотоодын зах зээлд тэргүүн ээлжид нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

21.1.6.хөрөнгө оруулалт татах, инновац, дэвшилтэт технологи нэвтрүүлэх таатай орчныг бий болгох;

21.1.7.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн экспортыг нэмэгдүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх;

21.1.8.олон улсын чиг хандлагад нийцүүлж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нэр хүндийг өсгөх, соёлыг үнэлэх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх;

21.1.9.соёлын бүтээлч үйлдвэрлэл дэх технологийн хөгжлийг дэмжих;

21.1.10.соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

21.1.11.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний зөвлөлийг төрийн байгууллага, дээд боловсрол, эрдэм шинжилгээний байгуулага, мэргэжлийн холбоодын төлөөллийн оролцоотой байгуулах, ажиллах журмыг батлах;

21.1.12.хуульд заасан бусад.

**22 дугаар зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

22.1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэгдсэн бодлогоор дэмжих, салбар хоорондын уялдааг хангах;

22.1.2.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээ, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, тайлагнах;

22.1.3.энэ хуулийн 22.1.2-т заасан төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх асуудлаар хүн, хуулийн этгээд, төр болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтран ажиллах;

22.1.4.улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр соёлын бүтээлч үйлдвэрлэлд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг бодлого, удирдлагаар хангах;

22.1.5.соёлын бүтээлч үйлдвэрлэлтэй холбоотой хуульд заасан дүрэм, журам, аргачлал батлах;

22.1.6.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зах зээлийн эрэлт, нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэрэгцээг судлах, хөгжлийн чиг хандлага, ирээдүйд бий болох эрэлт, хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэх, инновац, дэвшилтэт технологи нэвтрүүлэх чиглэлээр олон улсын хөгжлийн байгууллагатай хамтран ажиллах;

22.1.7.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаарх тайланг Засгийн газарт танилцуулах;

22.1.8.хуульд заасан бусад.

22.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн брэндийг хөгжүүлж, олон улсын зах зээлд гаргах, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нэр хүндтэй олон улсын үзэсгэлэн, уралдаан, наадам, бусад үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулна.

**23 дугаар зүйл.Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

23.1.Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

23.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж, Засгийн газрын болон сайдын шийдвэрийн биелэлтийг хангуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

23.1.2.соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгаа, хөгжүүлэлтийг зах зээлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

23.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бүртгэх, хадгалах, түгээх, ашиглахад дэмжлэг үзүүлэх;

23.1.4.холбогдох хуулийн хүрээнд телевиз, радиогийн уран сайхны нийтлэл, нэвтрүүлгийн орчинд эрх бүхий байгууллагатай хамтран хяналт тавих.

**24 дүгээр зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

24.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах;

24.1.2.тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, дэд бүтцийн хөгжил, төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх байршлыг тогтоох, дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, төсөв батлах;

24.1.3.энэ хуулийн 4.1-д заасан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, цогцолбор, кластер, инкубаторын төлөвлөлтийг аймаг, сум, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгах, хэрэгжилтийг хангуулах;

24.1.4.харьяалах нутаг дэвсгэртээ соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

**25 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

25.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, зорилтот хөтөлбөр, журмын хэрэгжилтийг хангах, бодлогын баримт бичигт нийцүүлэн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогтой уялдуулан соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

25.1.2.харьяалах нутаг дэвсгэртээ соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, парк, цогцолбор, кластер, инкубатор хөгжүүлэх, орон нутгийн онцлог бүхий соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх, бүтээх, үйлдвэрлэх, түгээхэд дэмжлэг үзүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, төсөв, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

25.1.3.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, цогцолбор байгуулах газрыг эзэмшүүлэх асуудлыг Газрын тухай хуулийн[8] 33.1.2-т заасны дагуу төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр шийдвэрлэх;

[8] Газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

25.1.4.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаар олгогдсон газрыг зориулалтын дагуу ашиглуулах, түүнд хяналт тавих.

**26 дугаар зүйл.Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх**

26.1.Сум, дүүргийн Засаг дарга соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

26.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж, бодлого, зорилтот хөтөлбөр, журмын хэрэгжилтийг хангах, төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогтой уялдуулан соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх;

26.1.2.энэ хуулийн 4.1-д заасан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, парк, цогцолбор, кластер, инкубатор байгуулах, орон нутгийн онцлогт нийцсэн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хөгжүүлэх, бүтээх, үйлдвэрлэх, түгээхэд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх, сурталчлах арга хэмжээ авах;

26.1.3.хуульд заасан бусад.

**27 дугаар зүйл.Аймаг, нийслэлийн Соёл урлагийн газрын бүрэн эрх**

27.1.Аймаг, нийслэлийн Соёл урлагийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас болон холбогдох бусад байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

27.1.2.тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, дэд бүтцийн хөгжил, төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх нутаг дэвсгэр, байршлыг тогтооход дэмжлэг үзүүлэх;

27.1.3.энэ хуулийн 4.1-д заасан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, цогцолбор, кластер, инкубаторыг байгуулах төлөвлөлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

27.1.4.хуульд заасан бусад.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

### 28 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ил тод байдал

28.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч, хөрөнгө оруулагч, хамтын удирдлагын байгууллага энэ хуулийн дагуу авсан дэмжлэг, үйл ажиллагааны тухайн жилийн тайлангаа дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад, төрийн захиргааны байгууллага нь тайланг нэгтгэн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

28.2.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 28.1-д заасан тайланг тухайн жилийн 2 дугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

28.3.Энэ хуулийн 14.3-т заасан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүртгэл, мэдээллийн сангаар дамжуулж соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.

28.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч, хөрөнгө оруулагч болон хамтын удирдлагын байгууллагын бүртгэл, төрөөс олгосон дэмжлэгийг ил тод мэдээлнэ.

### 29 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд[9] заасан хариуцлага хүлээлгэнэ.

29.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль[10], эсхүл Зөрчлийн тухай хуульд[11] заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

---
[9] Төрийн албан тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[10] Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 07 дугаарт нийтлэгдсэн.
[11] Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

Moelgo& Folo_ oa Heoll

[illegible]

᠒ [illegible]

᠒.᠑. [illegible]

᠒.᠑.᠑. «[illegible]» [illegible]

᠒.᠑.᠒. «[illegible]» [illegible]

᠒.᠑.᠓. «[illegible]» [illegible]

᠒.᠑.᠔. «[illegible]» [illegible]

᠒.᠑.᠕. «[illegible]» [illegible]

᠒.᠑.᠖. «[illegible]» [illegible]

᠒.᠑.᠗. «[illegible]» [illegible]

᠒.᠑.᠘. «[illegible]» [illegible]

᠒.᠑.᠙. «[illegible]» [illegible]

[illegible]

[illegible]

᠒.᠔.᠔.᠔. ᠳᠠᠭᠤ · ᠴᠢᠮᠡᠭᠡ ᠶᠢᠨ ᠲᠦᠪᠰᠢᠨ · ᠬᠥᠳᠡᠯᠭᠡᠭᠡᠨ ᠴᠢᠷᠢᠭ · ᠴᠢᠴᠢᠷᠭᠡᠯᠲᠡ · ᠰᠣᠷᠠᠨᠵᠢᠨ ᠳᠤᠯᠭᠢᠶ᠎ᠠ ᠶᠢ ᠬᠡᠮᠵᠢᠭᠦᠷ ᠢᠶᠡᠷ ᠬᠡᠮᠵᠢᠨᠡ ;

᠒.᠔.᠔.᠓. ᠠᠭᠠᠷ ᠤᠨ ᠲᠣᠭᠤᠰᠤᠵᠢᠯᠲᠠ · ᠬᠣᠣᠷᠠᠯᠠᠯ ᠪᠣᠳᠠᠰ · ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠬᠡᠮᠵᠢᠭᠦᠷ ᠢᠶᠡᠷ ᠬᠡᠮᠵᠢᠨᠡ ;

᠒.᠔.᠔.᠒. ᠭᠡᠷᠡᠯᠲᠦᠭᠦᠯᠦᠭ · ᠳᠤᠯᠠᠭᠠᠴᠢᠯᠠᠯ · ᠴᠢᠭᠢᠭ · ᠠᠭᠠᠷ ᠤᠨ ᠬᠥᠳᠡᠯᠭᠡᠭᠡᠨ ᠢ ᠬᠡᠮᠵᠢᠭᠦᠷ ᠢᠶᠡᠷ ᠬᠡᠮᠵᠢᠨᠡ ;

᠒.᠔.᠔.᠑. ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠢ ᠬᠡᠮᠵᠢᠬᠦ ᠳᠦ ᠪᠠᠭᠠᠵᠢ ᠬᠡᠷᠡᠭᠰᠡᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠨ · ᠬᠡᠮᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠠᠭᠤᠤ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠢ ᠬᠠᠩᠭᠠᠨ · ᠬᠡᠮᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠢᠵᠦ · ᠦᠷ᠎ᠡ ᠳᠦᠩ ᠢ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠨ ᠬᠡᠮᠵᠢᠨᠡ ::

᠒.᠔.᠓. ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠢ ᠦᠨᠡᠯᠡᠬᠦ ᠳᠦ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠣᠷᠴᠢᠨ ᠲᠣᠭᠣᠷᠢᠨ ᠤ ᠬᠡᠮᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠦᠷ᠎ᠡ ᠳᠦᠩ ᠢ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠨ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠨᠡ ::

᠒.᠔.᠔. ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠢ ᠦᠨᠡᠯᠡᠬᠦ ᠮᠠᠶᠢᠭ ᠤᠨ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠠᠯ ᠪᠠᠷ ᠬᠡᠮᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠦᠷ᠎ᠡ ᠳᠦᠩ ᠢ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠨ ᠲᠡᠮᠳᠡᠭᠯᠡᠨᠡ ::

## ᠭᠤᠷᠪᠠᠳᠤᠭᠠᠷ ᠪᠦᠯᠦᠭ
## ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠦᠨ ᠦᠨᠡᠯᠡᠯᠭᠡ

᠓ ᠦᠨᠡᠯᠡᠯᠭᠡ ᠬᠢᠬᠦ :: ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠦᠨ ᠠᠩᠭᠢᠯᠠᠯ

᠓.᠑. ᠦᠨᠡᠯᠡᠯᠭᠡ ᠬᠢᠬᠦ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠢ ᠠᠩᠭᠢᠯᠠᠬᠤ ᠳᠤ ᠬᠣᠣᠷᠠᠯᠠᠯ · ᠬᠠᠯᠠᠭᠤᠨ · ᠰᠢᠷᠭᠢᠭᠰᠡᠨ · ᠬᠦᠨᠳᠦ ᠪᠠ ᠬᠦᠴᠦᠷ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠲᠦ ᠬᠠᠮᠠᠷᠤᠯᠤᠨ ᠠᠩᠭᠢᠯᠠᠨ᠎ᠠ ::

᠓.᠒. ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠢ ᠦᠨᠡᠯᠡᠬᠦ ᠳᠦ ᠡᠷᠦᠬᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ · ᠠᠶᠤᠯᠭᠦᠢ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠦᠨ ᠦᠨᠡᠯᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠬᠦᠷᠦᠭᠰᠡᠨ ᠡᠰᠡᠬᠦ ᠶᠢ
ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠲᠠᠯ ᠠᠴᠠ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ · ᠡᠷᠦᠬᠦᠯ ᠮᠡᠨᠳᠦ ᠶᠢᠨ ᠭᠣᠷᠪᠠᠳᠤᠭᠠᠷ ᠰᠤᠷᠠᠯ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠨ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠦᠨ ᠠᠩᠭᠢᠯᠠᠯ ᠲᠤ
ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ ::

᠓.᠓. ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠡᠴᠡ ᠓.᠒ — ᠳᠤ ᠵᠠᠭᠠᠭᠰᠠᠨ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ · ᠬᠥᠳᠡᠯᠮᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠨᠥᠬᠥᠴᠡᠯ ᠦᠨ ᠬᠠᠷᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠰᠦᠨᠦᠭ ᠲᠦ ᠪᠠᠢᠷᠢᠰᠢᠭᠤᠯᠤᠨ ᠙᠒ — ᠙᠖
ᠬᠤᠪᠢ ᠪ ᠬᠤᠪᠢᠶᠠᠷ ᠳᠤ ᠲᠤ ᠪᠠᠢᠨ ᠬᠡᠮᠵᠢᠭᠳᠡᠨ᠎ᠡ ::

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠑᠐ [illegible]

᠑᠐.᠑. [illegible]

᠑᠐.᠒. [illegible] ᠑᠐.᠑ — [illegible]

᠑᠐.᠓. [illegible]

᠑᠑ [illegible]

᠑᠑.᠑. [illegible]

᠑᠑.᠑.᠑. [illegible]

᠑᠑.᠑.᠒. [illegible]

᠑᠑.᠑.᠓. [illegible]

᠑᠑.᠑.᠔. [illegible]

᠑᠑.᠑.᠕. [illegible]

᠑᠑᠂᠖᠂ᠶᠢᠨ [illegible] ᠳᠤ ᠑᠐᠂᠑᠂ ᠑᠑᠂᠑ – ᠪᠡᠷ [illegible] ᠃

᠑᠙ [illegible] ᠃

᠑᠙᠂᠑᠂᠗᠂ [illegible] ᠄

᠑᠙᠂᠑᠂᠖᠂ [illegible] ᠄

᠑᠙᠂᠑᠂᠕᠂ [illegible] ᠄

᠑᠙᠂᠑᠂᠔᠂ [illegible] ᠄

᠑᠙᠂᠑᠂᠖᠂ [illegible] ᠃

᠑᠙᠂᠙᠂ [illegible] ᠃

[illegible]

[illegible]

᠑᠗·᠔·᠑· [illegible]

᠑᠗·᠔·᠒· [illegible]

᠑᠗·᠕· [illegible]

᠑᠗·᠕·᠑· [illegible]

᠑᠗·᠕·᠒· [illegible]

᠑᠗·᠕·᠓· [illegible]

᠑᠗·᠕·᠔· [illegible]

᠑᠗·᠕·᠕· [illegible]

᠑᠗·᠕·᠖· [illegible]

᠑᠗·᠖· [illegible] ᠑᠗·᠕ — [illegible]

᠑᠗·᠗· [illegible]

᠑᠗·᠗·᠑· [illegible]

᠑᠗·᠗·᠒· [illegible]

᠑᠗·᠗·᠓· [illegible]

[illegible]

᠓.᠑.᠑.᠓. ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭᠣᠯᠲᠠ᠂ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ ᠶᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ
ᠬᠠᠮᠢᠶᠠ ;

᠓.᠑.᠑.᠔. ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭ᠎ᠠ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠠᠵᠢᠯ ᠲᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠵᠢᠴ᠎ᠡ ᠶᠢ ᠠᠰᠢᠭᠯᠠᠬᠤ ;

᠓.᠑.᠑.᠕. ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭᠣᠯᠲᠠ᠂ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠵᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ
ᠬᠠᠮᠲᠤ ᠪᠡᠷ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠪᠡᠷ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ;

᠓.᠑.᠑.᠖. ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ᠂ ᠲᠠᠢᠯᠠᠩ᠂ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠡᠯᠡᠳᠬᠡᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ;

᠓.᠑.᠑.᠗. ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭᠣᠯᠲᠠ᠂ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠬᠤ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠵᠢᠴ᠎ᠡ ᠶᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ;

᠓.᠑.᠑.᠘. ᠬᠠᠮᠲᠤ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠪᠡᠷ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭᠣᠯᠲᠠ᠂ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ ᠲᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ᠂
ᠶᠠᠮᠤᠨ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ;

᠓.᠑.᠑.᠙. ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭᠣᠯᠲᠠ᠂ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ;

᠓.᠑.᠑.᠑᠐. ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭᠣᠯᠲᠠ᠂ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠵᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠬᠢᠨᠠᠬᠤ ᠶᠢ
ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ;

᠓.᠑.᠑.᠑᠑. ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭᠣᠯᠲᠠ᠂ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ ᠵᠢᠴ᠎ᠡ ᠶᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠭᠤᠯᠬᠤ᠂ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ᠂ ᠠᠵᠢᠯ
ᠠᠵᠢᠯᠯᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠠ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠭᠤᠯᠬᠤ᠂ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠭᠡᠨ ᠦ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ;

᠓.᠑.᠑.᠑᠓. ᠬᠠᠮᠲᠤ ᠪᠡᠷ ᠰᠠᠨᠠᠯ ᠪᠣᠯᠤᠮᠵᠢ ::

«« ᠪᠦᠯᠦᠭ ᠬᠣᠷᠢᠨ :: ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠰᠠᠢᠳ ᠤᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠪᠠᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠤ
ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠷ ᠪᠣᠯᠤᠨ ᠠᠵᠢᠯ

᠓᠓.᠑. ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠰᠠᠢᠳ ᠤᠨ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠪᠠᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠠᠮᠤᠨ ᠤ ᠪᠣᠳᠣᠯᠭᠣᠯᠲᠠ᠂ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ
ᠮᠠᠰᠢᠨ ᠪᠠᠢᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠨ :

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдол бүрийг бүртгэх, хянах системийн тоног төхөөрөмжийг соёлын бүтээгдэхүүний төрлөөс хамаарч нэвтрүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг төрөөс нэг удаа үзүүлнэ.

**2 дугаар зүйл.**Соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах тохиолдол бүрийг бүртгэх, хянах системийг хөгжүүлэх зардлын дэмжлэгийг 5 жилийн хугацаанд хуулийн этгээд, холбогдох хамтын удирдлагын байгууллагыг сонгосны үндсэн дээр үзүүлнэ.

**3 дугаар зүйл.**Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль батлагдахаас өмнө төлсөн татвар, хураамж уг хуульд заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахгүй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

Moehgo& Folo_ oa Heol I

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Соёлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.9, 3.1.10 дахь заалт:**

“3.1.9.“соёлын агуулга” гэж соёлын өвөрмөц хэв шинжээс үүдэлтэй буюу түүнийг илэрхийлэх бэлгэдлийн утга санаа, уран сайхны агуулгыг;

3.1.10.“контент” гэж үг, дуу, тэмдэг, дохио, текст, зураг, график, хөдөлгөөнт дүрс бүхий бүх төрлийн мэдээ, мэдээллийг тоон болон мультимедиа хэлбэрт хувиргасан агуулгыг.”

**2/18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэг:**

“18.6.Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.**Соёлын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт:**

“3.1.4.“соёлын бүтээгдэхүүн” гэж соёлын агуулга бүхий эдийн засгийн нэмүү өртөг шингэсэн биет болон биет бус зүйл, контентыг;”

**2/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалт:**

“3.1.6.“соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэж хүний оюун санаа, авьяас, чадвар, бүтээлч сэтгэлгээний үр дүнд технологи, инновац, оюуны өмчид суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, бүтээх, үйлдвэрлэх, түгээх үйл явцыг;”

**3 дугаар зүйл.**Соёлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “соёлын, боловсрол, шинжлэх ухааны

болон эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран” гэж, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн “Шилдэг бүтээл” гэснийг “Шилдэг уран бүтээлч болон шилдэг бүтээл” гэж, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтын “уран сайхны” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “тус” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Соёлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

Moehgo& Folo_ oa Heol

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢᠯᠡᠭᠴᠢ ᠦ.ᠬᠦᠷᠡᠯᠰᠦᠬ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 36 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 36.4 дэх хэсэг нэмсүгэй:

“36.4.Соёлын биет өвийн загварыг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид ашиглуулна.”

**2 дугаар зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсгийн “захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52 дугаар зүйлийн “54.15.1” гэснийг “52.15.1” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.16 дахь хэсгийн “хосгүй үнэт” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

Moehgo& Folo_ oa Heol I

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/15 дугаар зүйлийн 15.1.16 дахь заалт:**

“15.1.16.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор албан татвар ногдох орлогын 5 хувиас хэтрэхгүйгээр өгсөн хандив.”

**2/22 дугаар зүйлийн 22.5.21 дэх заалт:**

“22.5.21.соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн үндсэн үйл ажиллагаанд ногдох орлогын албан татварыг эрх бүхий байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаа явуулах эхний 3 жилд 90 хувь, дараагийн 3 жилд 50 хувиар.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

[illegible]

Moengo& Folo_ oa Heoll

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.1.8 дахь заалт нэмсүгэй:

“11.1.8.шинээр барилга барих, сэргээн засах, түүхийн дурсгалт барилга байгууламжийн эзлэхүүнт орон зай, орчин, нүүр болон шинэ талд үндэсний агуулга, хэлбэр, дүр төрхийг илэрхийлсэн үзэл баримтлал, шинэ санаа, шийдэл гаргах, архитектурын бүтээл туурвиж бий болгох, төлөвлөх.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр | Улаанбаатар хот

## ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.19 дэх заалт нэмсүгэй:

“16.1.19.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор, паркын зориулалтаар олгосон газар.”

**2 дугаар зүйл.**Газрын тухай хуулийн 16.2 дахь хэсгийн “16.1.17” гэсний дараа “, 16.1.19” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.23 дахь заалт нэмсүгэй:

“38.1.23.Монгол Улсад бүтээх боломжгүй том хэмжээний уран баримал, урлагийн бүтээлийг болон гадаад улсаас Монгол Улсад авчрах соёлын өвийн хуулбар.”

**2 дугаар зүйл.**Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “жагсаалтыг” гэснийг “жагсаалт, 38.1.23-т заасан барааг нэр төрөл тус бүрээр тухай бүр” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

Moehgol Folo_ oa Heol

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “5.3.5,” гэсний дараа “5.3.13,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“**13 дугаар зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан**

13.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ, контентын олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зориулалттай байна.

13.2.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгө энэ хуулийн 6.1-д зааснаас гадна соёлын үнэт зүйлийн загварыг ашиглуулснаас бий болсон орлогын 10 хүртэлх хувийн эх үүсвэрээс бүрдэнэ.

13.3.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

13.3.1.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн мэдээллийн сан байгуулж, баяжуулах;

13.3.2.соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээ, контент бий болгох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

13.3.3.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

13.3.4.технологи нэвтрүүлэх, технологийн шинэчлэлт хийх;

13.3.5.олон улсын арга хэмжээг гадаадад болон өөрийн оронд зохион байгуулах;

13.3.6.соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа хийх;

13.3.7.соёл урлагийн байгууллагад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг худалдан авах;

13.3.8.хөгжмийн том хэмжээний болон дүрслэх урлаг, ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах;

13.3.9.олон улсын хэмжээний наадам, тэмцээн, үзэсгэлэн, яармагт уран бүтээлчийг оролцуулах, түүнд онцгой амжилт гаргасан иргэнийг шагнаж урамшуулах;

13.3.10.үндэсний соёл урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг алдаршуулах;

13.3.11.монгол судлаачийг бэлтгэх, монгол судлаач, эрдэмтний шилдэг бүтээлийг шалгаруулж, хэвлүүлэх, сурталчлахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

13.4.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.13 дахь заалтын “Соёл, урлагийг дэмжих сан” гэснийг “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

Moehgo& Folo_ oa Heol I

᠑᠓.᠓.᠖. [illegible] ;

᠑᠓.᠓.᠗. [illegible] ;

᠑᠓.᠓.᠘. [illegible] ;

᠑᠓.᠓.᠙. [illegible] ;

᠑᠓.᠓.᠑᠐. [illegible] ;

᠑᠓.᠓.᠑᠑. [illegible]

᠑᠓.᠔. [illegible] ::

᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ :: [illegible] ::

᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ :: ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ [illegible] ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠦᠷᠳᠡᠨ᠎ᠡ ::

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠳ᠂ ᠠᠮᠤᠷᠪᠠᠶᠠᠰᠬᠤᠯᠠᠩ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 9.14 дүгээр зүйл нэмсүгэй:

“**9.14 дүгээр зүйл.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг зөрчих**

1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэмжлэгийн тайлангаа хугацаанд нь гаргаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч, хамтын удирдлагын байгууллага, хөрөнгө оруулагчид үзүүлсэн дэмжлэгийг зориулалт бусаар ашигласан, эсхүл хуурамч баримт ашиглан дэмжлэг авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох, хянах, хэрэглэгчийн статистик мэдээлэлд үндэслэн хязгаарлалт тогтоохтой холбогдсон журмыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/9.7 дугаар зүйлийн 1.3 дахь заалт:**

“1.3.соёлын биет өвийг зөвшөөрөлгүй зөөж тээвэрлэсэн, зөөж тээвэрлэх нөхцөл журмыг зөрчсөн;”

**2/9.7 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Нийтийн өмчийн соёлын биет өвийг зөвшөөрөлгүй хувилан олшруулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

᠕ ᠬᠡᠰᠡᠭ᠄ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠦᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ᠂ ᠵᠢᠷᠤᠮ ᠢ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠡᠷᠢᠭᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ᠃

᠖/᠑ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠖.᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠨᠡᠮᠡᠭᠰᠡᠭᠡᠶ᠄

«᠖.᠓.ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠬᠢᠬᠦ ᠡᠷᠬᠡ ᠦᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠵᠢᠷᠤᠮ ᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ᠃»

᠖/᠑ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ ᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄

«᠖.᠑.ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠦᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ᠂ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠦᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠡᠷᠢᠭᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ᠃»

᠒ ᠬᠡᠰᠡᠭ᠄ᠬᠠᠷᠢᠶᠠᠯᠠᠯ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠦᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠵᠢᠷᠤᠮ ᠢ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠡᠷᠢᠭᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠳ᠂ ᠠᠮᠠᠷᠪᠠᠶᠠᠰᠬᠤᠯᠠᠩ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.46 дахь заалтын “9.13,” гэсний дараа “9.14,” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр — Улаанбаатар хот

## ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зар сурталчилгааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “дэмжин тэтгэх” гэсний дараа “болон соёлын өвийг хамгаалах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр — Улаанбаатар хот

## КИНО УРЛАГИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “үүсвэрээс” гэсний дараа “болон гадаадын киног Монгол Улсад гаргасны ашгийн 2 хувиас” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Кино урлагийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай” гэснийг “Кино урлагийн зөвлөл, Харилцаа холбооны зохицуулах хороотой” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр — Улаанбаатар хот

## НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Номын сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 18.1-д заасан” гэснийг, мөн зүйлийн 18.6 дахь хэсгийн “18.1,” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Номын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 34.28 дахь хэсэг нэмсүгэй:

“34.28. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн мэдээллийг гаргаж, татварын албанд хүргүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2 дахь хэсгийн “34.27” гэсний дараа “, 34.28” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2024 он №26/1322/

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалтын “үйлдвэр барих” гэсний дараа “болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор, парк, дэд бүтэц барих” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалтын “аргачлалыг” гэсний дараа “соёлын болон” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.2.7.“соёлын биет өвийн үнэлгээний журам, аргачлалыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай, эрдэнэсийн үнэлгээний журам, аргачлалыг Монголбанк болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тус тус хамтран;”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠯᠡ

[illegible] ᠣᠨ ᠤ [illegible] ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ [illegible] — ᠤ ᠡᠳᠦᠷ

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible] ᠤ ᠲᠤᠬᠠᠢ
ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ
ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠄ [illegible]

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ [illegible]

[illegible]

᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ [illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

ᠭ᠂ ᠵᠠᠩᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

## ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хот байгуулалтын тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.3 дахь хэсэг нэмсүгэй:

“17.3.Хот, тосгоны захирагч үндэсний агуулгыг илэрхийлсэн хэлбэр, дүр төрх, орчныг төлөвлөж хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “санал гаргах” гэсний өмнө “ерөнхий төлөвлөгөө, тохижилт, барилга байгууламжийн архитектур төлөвлөлтөд үндэсний хэв маяг, дүр төрхийг илэрхийлсэн шийдэл тусгах” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

Moelgo& Folo_ oa Heol

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

## ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчний болон цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох хууль тогтоомж

2.1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль[2], Зэвсэгт хүчний тухай хууль[3], Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль[4], Цагдаагийн албаны тухай хууль[5], Олон улсын гэрээний тухай хууль[6], Засгийн газрын тусгай сангийн тухай хууль[7] болон энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Энхийг дэмжих ажиллагаан дахь Монгол Улсын оролцоо нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн шийдвэр, хоёр талын болон олон улсын гэрээнд нийцсэн байна.

---
[1] Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[2] Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.
[3] Зэвсэгт хүчний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.
[4] Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.
[5] Цагдаагийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 08 дугаарт нийтлэгдсэн.
[6] Олон улсын гэрээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 02 дугаарт нийтлэгдсэн.
[7] Засгийн газрын тусгай сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“энхийг дэмжих ажиллагаа” гэж олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын, эсхүл бүс нутгийн холбогдох байгууллага, аливаа улсын удирдлага, зохион байгуулалтын доор явагдаж байгаа олон үндэстний нэгдсэн ажиллагааг;

3.1.2.“бие бүрэлдэхүүн” гэж энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор бэлтгэгдэж, томилогдсон цэргийн болон цагдаагийн алба хаагчдыг;

3.1.3.“цэргийн болон цагдаагийн баг” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон бүтэц, орон тооны дагуу бие бүрэлдэхүүн болон зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгслээр хангагдсан, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх нэгжийг;

3.1.4.“энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэл” гэж олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачилгаар зохион байгуулж байгаа тухайн энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүргийн онцлог, тавигдах шаардлагыг хангахад чиглэсэн мэдлэг, дадлага, ур чадвар олгох, жигдрэлтийг хангах арга хэмжээний нэгдлийг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

**4 дүгээр зүйл.Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч**

4.1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүн нь цэргийн болон цагдаагийн алба хаагч, баг байна.

4.2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн нь сайн дурын үндсэн дээр сонгогдож, тухайн ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэлд бүрэн хамрагдсан байна.

4.3.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох цэргийн алба хаагчийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, цагдаагийн алба хаагчийг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилно.

4.4.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон цэргийн болон цагдаагийн алба хаагчийг албан ажлын шаардлагыг харгалзан өөртэй нь тохиролцож, саналыг бичгээр авсны дагуу энхийг дэмжих ажиллагаанаас ирэх хүртэлх хугацаанд эрх бүхий албан тушаалтан үндсэн албан тушаалаас нь өөр албан тушаалд шилжүүлэн томилж болно.

4.5.Цэргийн болон цагдаагийн алба хаагч Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж, үүрэг гүйцэтгэх тохиолдолд албанаас чөлөөлнө.

**5 дугаар зүйл.Энхийг дэмжих ажиллагаанд гүйцэтгэх үүрэг**

5.1.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд дараах төрлийн үүрэг гүйцэтгүүлэхээр Зэвсэгт хүчний цэргийн алба хаагч, багийг оролцуулна:

5.1.1.энгийн иргэнийг хамгаалах;
5.1.2.гал зогсоох гэрээний биелэлтэд хяналт тавих;
5.1.3.мөргөлдөгч талуудыг тусгаарлах, зэвсэг хураах;
5.1.4.зэвсэгт мөргөлдөөний хор уршгийг арилгах;
5.1.5.инженерийн болон бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх;
5.1.6.дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
5.1.7.эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх;
5.1.8.аюулгүй байдлыг хангах байгууллагын бие бүрэлдэхүүнийг сургах;

5.1.9.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн мандатаар тогтоосон бусад үүрэг.

5.2.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд дараах төрлийн үүрэг гүйцэтгүүлэхээр цагдаагийн алба хаагч, багийг оролцуулна:

5.2.1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын бие бүрэлдэхүүн болон эд хөрөнгийг хамгаалах;

5.2.2.энгийн иргэнийг хамгаалах;
5.2.3.Нэгдсэн Үндэстний Байгууллагын цагдаагийн албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

5.2.4.нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах;

5.2.5.үүрэг гүйцэтгэх улсын цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, алба хаагчдыг сургаж бэлтгэх;

5.2.6.хүмүүнлэгийн байгууллагын үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх;

5.2.7.Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн мандатаар тогтоосон бусад үүрэг.

5.3.Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэргийн болон цагдаагийн алба хаагч, баг дараах нийтлэг үүргийг хүлээнэ:

5.3.1.Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цагдаагийн албаны дүрэм, эрх бүхий байгууллага, цэргийн болон цагдаагийн багийн захирагчийн тушаалаар тогтоосон журам, зааврыг дагаж мөрдөх;

5.3.2.Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулагчийн, өөрийн орны цэргийн болон цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлах;

5.3.3.тухайн ажиллагаанд заасан үүргийн хүрээнд ахлах даргын тушаал, шийдвэрийг биелүүлэх, захирах, захирагдах ёсыг баримтлах;

5.3.4.өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх;

5.3.5.үүрэг гүйцэтгэх улсын хууль тогтоомжийг мөрдөх, зан заншил, шашин шүтлэгт нь хүндэтгэлтэй хандах;

5.3.6.цагийн байдлын өөрчлөлт, үүрэг гүйцэтгэх үеийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрхийн хязгаарлалтыг дагаж мөрдөх.

5.4.Энхийг дэмжих ажиллагаанд цэргийн болон цагдаагийн алба хаагч, багийг илгээснээр цэргийн алба хаагч, баг нь энхийг дэмжих ажиллагааны Цэргийн хүчний командлагчийн, цагдаагийн алба хаагч, баг нь Цагдаагийн комиссарын ажиллагааны удирдлагад шилжинэ.

5.5.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн болон цагдаагийн алба хаагч, баг Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, журам, олон улсын гэрээг зөрчсөн, сахилгын ноцтой зөрчил гаргасан, түүнчлэн гэмт хэрэгт холбогдон хугацаанаас нь өмнө эгүүлэн татах тохиолдолд холбогдох зардлыг тухайн алба хаагч хариуцна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 6 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1.Монгол Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.энхийг дэмжих ажиллагаанд оролцох эрх зүйн үндсийг тогтоох;

6.1.2.энэ хуулийн 7.1.3-т заасан зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах.

### 7 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

7.1.Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн цэргийн болон цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах, эгүүлэн татах шийдвэр гаргах;

7.1.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцох асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, бүс нутгийн холбогдох байгууллага, бусад улстай гэрээ, хэлэлцээр байгуулах;

7.1.3.энхийг дэмжих ажиллагаанд оролцох Зэвсэгт хүчин, цагдаагийн байгууллагын чадавхыг бүрдүүлэх, шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7.1.4.энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэлийг өөрийн оронд зохион байгуулах, гадаад улсад энэ төрлийн арга хэмжээнд бие бүрэлдэхүүнийг оролцуулах шийдвэр гаргах;

7.1.5.Монгол Улсаас хилийн чанадад энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн болон өөрийн оронд зохион байгуулах энэ төрлийн сургалт, бэлтгэлд оролцох гадаад орны бие бүрэлдэхүүн, тэдгээрийн зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд хэрэгсэлд хил, гаалийн шалгалт хийх, навигацийн болон бусад үйлчилгээний журмыг тогтоох;

7.1.6.Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олгосон нөхөн төлбөрөөс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд олгох томилолтын зардал, Зэвсэгт хүчний болон Цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоох;

7.1.7.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг санхүүжүүлэх журмыг тогтоох.

**8 дугаар зүйл.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

8.1.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.энхийг дэмжих ажиллагаатай холбоотой асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран судалж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

8.1.2.энхийг дэмжих ажиллагаатай холбоотой асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, холбогдох улс, бүс нутгийн байгууллагатай харилцаж, зохицуулах;

8.1.3.гадаад улсад энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцож байгаа бие бүрэлдэхүүний эрхийг хамгаалах;

8.1.4.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон олон улсын гэрээгээр тогтоосон дүрэм, журам зөрчсөн, сахилгын ноцтой зөрчил гаргасан, нас барсан, шархадсан, ар гэрийн, эсхүл эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд эх оронд нь эгүүлэн татах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

**9 дүгээр зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

9.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.зэвсэгт хүчний цэргийн багийг энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцуулах асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

9.1.2.цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын сонгож санал болгосноор энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнийг томилох, хугацааг сунгах, эгүүлэн татах, ажиллагааны үүрэг гүйцэтгэлтийг дуусгавар болгох шийдвэр гаргах;

9.1.3.энэ хуулийн 8.1.4-т заасан шалтгаанаар цэргийн алба хаагч, багийг эгүүлэн татах ажлыг зохион байгуулах;

9.1.4.цэргийн алба хаагч, багийн энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангуулах асуудлыг боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.5.Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт мэдээлэх;

9.1.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг энэ хуулийн 7.1.6-д заасан хувь хэмжээг баримтлан захиран зарцуулах;

9.1.7.энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах, сургаж бэлтгэх, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журмыг батлах;

9.1.8.энэ хуулийн 8.1.4-т заасан шалтгаанаар цэргийн алба хаагчийг эгүүлэн татах үед дараагийн алба хаагчаар нөхөн хангах эсэх асуудлыг шийдвэрлэх;

9.1.9.энэ хуулийн 7.1.6-д заасан хувь хэмжээний талаарх санал боловсруулж, Засгийн газраар шийдвэрлүүлэх;

9.1.10.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд томилолтын зардал олгох журмыг батлах;

9.1.11.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг батлах.

**10 дугаар зүйл.Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

10.1.Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцуулах асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

10.1.2.цагдаагийн төв байгууллагаас сонгож санал болгосон энхийг дэмжих ажиллагаа, сургалт, бэлтгэлд оролцох цагдаагийн

алба хаагч, багийг томилох, хугацааг сунгах, эгүүлэн татах, ажиллагааны үүрэг гүйцэтгэлтийг дуусгавар болгох шийдвэр гаргах;

10.1.3.энэ хуулийн 8.1.4-т заасан шалтгаанаар цагдаагийн алба хаагч, багийг эгүүлэн татах ажлыг зохион байгуулах;

10.1.4.энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийг энэ хуулийн 7.1.6-д заасан хувь хэмжээг баримтлан захиран зарцуулах;

10.1.5.цагдаагийн алба хаагч, багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангуулах асуудлыг боловсруулж хэрэгжүүлэх;

10.1.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцох цагдаагийн алба хаагч, багийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх үед дагаж мөрдөх журмыг батлах;

10.1.7.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах журмыг батлах.

**11 дүгээр зүйл.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын бүрэн эрх**

11.1.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагч, багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах;

11.1.2.энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа цэргийн алба хаагч, багийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих;

11.1.3.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчтай гэрээ байгуулах, дүгнэх, түүний биелэлтэд хяналт тавих;

11.1.4.энхийг дэмжих ажиллагаанд шинээр оролцуулах цэргийн багийг Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх, бэлтгэлийг хангах, илгээх асуудлыг холбогдох байгууллагад уламжлах;

11.1.5.тухайн газар орны хариуцлагын бүс дэх нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан цэргийн алба хаагч, багийн аюулгүй байдалд ноцтой аюул, заналхийлэл учирсан тохиолдолд тухайн

ажиллагааны дээд штабтай харилцан ажиллаж, эрх бүхий албан тушаалтан, байгууллагыг мэдээллээр хангах, санал танилцуулах;

11.1.6.цэргийн алба хаагч, багийн үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны цагийн байдлын талаар хагас жил тутам, шаардлагатай үед Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тухай бүр мэдээлэх;

11.1.7.цэргийн алба хаагч, багийн үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах саналыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулах;

11.1.8.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах;

11.1.9.энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургамжийг судлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох.

**12 дугаар зүйл.Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх**

12.1.Цагдаагийн төв байгууллагын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагч, багийн ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах;

12.1.2.цагдаагийн алба хаагч, багийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих;

12.1.3.энхийг дэмжих ажиллагаанд шинээр оролцуулах цагдаагийн багийг бэлтгэх үед Нэгдсэн Үндэстний Байгууллагад бүртгүүлэх, бэлтгэлийг хангах, илгээх асуудлыг холбогдох байгууллагад уламжлах;

12.1.4.цагдаагийн алба хаагч, багийн үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны цагийн байдлын талаар хагас жил тутам, шаардлагатай үед тухай бүр хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдээлэх;

12.1.5.цагдаагийн алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд нэр дэвшүүлэх, үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах, эгүүлэн татах саналыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, шийдвэрлүүлэх;

12.1.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах ажлыг зохион байгуулах.

**13 дугаар зүйл.Цэргийн болон цагдаагийн багийн захирагчийн нийтлэг эрх, үүрэг**

13.1.Цэргийн болон цагдаагийн багийн захирагч тактикийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

13.2.Цэргийн болон цагдаагийн багийн захирагч нь тухайн багт нэгдмэл удирдлага, нэгтгэн захирах ёсыг хэрэгжүүлэгч, нийт бие бүрэлдэхүүний шууд захирах дарга бөгөөд дараах нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

13.2.1.сонгон шалгаруулалтад тэнцсэн бие бүрэлдэхүүний ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэлийг удирдан явуулах;

13.2.2.цэргийн болон цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, бие бялдар, ёс зүй, сахилга бат, нас, ажилласан жил, цол, ажиллагааны өмнөх сургалт, бэлтгэлийн үр дүнг үндэслэн албан тушаалд томилох, чөлөөлөх санал гаргах;

13.2.3.Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цагдаагийн албаны дүрэм, Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх зүйн баримт бичигт нийцүүлэн холбогдох тушаал, шийдвэр гаргаж, хэрэгжилтийг хангах;

13.2.4.цэргийн болон цагдаагийн багийн хэмжээнд цэргийн алба, цагдаагийн үйл ажиллагаа, сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, үүрэг гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулах, удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

13.2.5.бие бүрэлдэхүүний ажиллагааны үүрэг гүйцэтгэлт, сахилга хариуцлага, мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг харгалзан алба хаагчийг холбогдох албан тушаалд сэлгэн ажиллуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд гаргах;

13.2.6.бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг удирдан зохион байгуулах;

13.2.7.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн байдал, үр дүнг үнэлж Нэгдсэн Үндэстний Байгууллагын, эсхүл бусад байгууллагын шагнал, Монгол Улсын төрийн одон, медаль, салбарын

шагналаар алба хаагчийг шагнуулах саналыг холбогдох байгууллагад уламжлах;

13.2.8.энхийг дэмжих ажиллагаанд оролцсон туршлага, сургамжийн талаар санал, зөвлөмж боловсруулж, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын, эсхүл цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулах.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

### 14 дүгээр зүйл.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал

14.1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал нь уг ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр болон Нэгдсэн Үндэстний Байгууллага, бүс нутгийн байгууллага, тухайн ажиллагаа явагдаж байгаа улстай байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно.

14.2.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүн тухайн ажиллагааг удирдахаар Нэгдсэн Үндэстний Байгууллага, бүс нутгийн байгууллага, аливаа улсын шийдвэрээр томилогдсон олон үндэстний цэргийн хүчний командлагч, цагдаагийн комиссарын удирдлагад захирагдах бөгөөд энэ нь бие бүрэлдэхүүн энхийг дэмжих тухайн ажиллагааны бүсэд байх хугацаанд хамаарна.

14.3.Бие бүрэлдэхүүн нь цэргийн болон цагдаагийн дүрэмт хувцас, цолны болон ялгах тэмдэгтэй байх бөгөөд тухайн ажиллагааг удирдаж байгаа эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрээр тусгай таних тэмдэг хэрэглэж болно.

14.4.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх хугацаанд цэргийн болон цагдаагийн алба хаагчийн албан тушаалыг хэвээр хадгалж, өөрөө зөвшөөрсөн тохиолдолд цалин хөлсийг итгэмжлэгдсэн этгээдэд олгож болно.

14.5.Бие бүрэлдэхүүнээс энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай[8] хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

[8] Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 08 дугаарт нийтлэгдсэн.

14.6.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед алба хаагч хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох комиссын дүгнэлтийг харгалзан нөхөн олговор олгуулах эсэх асуудлыг судлан шийдвэрлүүлэхэд цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага, эсхүл цагдаагийн төв байгууллагаас дэмжлэг үзүүлнэ.

14.7.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн болон цагдаагийн алба хаагч ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй тохиолдолд холбогдох хуульд заасан мөнгөн урамшуулал олгоно.

14.8.Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнийг амь нас, эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулсан байх бөгөөд даатгалтай холбогдон гарах зардлыг тухайн ажиллагааг удирдаж байгаа эрх бүхий байгууллага, хоёр талын, эсхүл олон талт олон улсын гэрээнд тусгаагүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

14.9.Цэргийн болон цагдаагийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед гэмт хэрэг, зөрчилд холбогдсон тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

**15 дугаар зүйл.Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдох зардал**

15.1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдох зардал нь сургалт, бэлтгэл, хангалт, сонгон шалгаруулалт, оролцох үеийн зардлаас бүрдэх бөгөөд уг зардлыг жил бүрийн улсын төсвийн батлан хамгаалахын болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний арга хэмжээний зардалд тусгасан байна.

15.2.Энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа бие бүрэлдэхүүний цалин хөлс, хангамж, эдийн засгийн бусад баталгааг төр хариуцна.

**16 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

16.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

Moehgo& Folo_ oa Heol

᠓.᠑. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ [illegible] ᠄

᠓.᠑.᠑. «[illegible]» [illegible]

᠓.᠑.᠒. «[illegible]» [illegible]

᠓.᠑.᠓. «[illegible]» [illegible]

᠓.᠑.᠔. «[illegible]» [illegible]

ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠪᠦᠯᠦᠭ
[illegible]

᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ [illegible]

᠔.᠑. [illegible]

᠔.᠒. [illegible]

᠔.᠓. ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠥᠯᠦᠭᠡᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠣᠩᠭᠤᠭᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠷ᠎ᠡ ᠳᠡᠪᠰᠢᠭᠴᠢ ᠶᠢ ᠨᠠᠮ᠂ ᠡᠪᠰᠡᠯ [illegible] ᠪᠣᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠷᠤᠭᠳᠠᠬᠤ᠃

᠔.᠔. ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠥᠯᠦᠭᠡᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠣᠩᠭᠤᠭᠤᠯᠢ ᠳᠤ [illegible] ᠨᠠᠮ᠂ ᠡᠪᠰᠡᠯ [illegible] ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ᠃

᠔.᠕. [illegible] ᠨᠠᠮ᠂ ᠡᠪᠰᠡᠯ [illegible] ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠥᠯᠦᠭᠡᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠣᠩᠭᠤᠭᠤᠯᠢ ᠳᠤ [illegible] ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ᠃

᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠥᠯᠦᠭᠡᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠣᠩᠭᠤᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠣᠭᠣᠷᠢᠭ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ

᠕.᠑. ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠥᠯᠦᠭᠡᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠣᠩᠭᠤᠭᠤᠯᠢ ᠳᠤ [illegible] ᠲᠣᠭᠣᠷᠢᠭ [illegible] ᠨᠡᠷ᠎ᠡ ᠳᠡᠪᠰᠢᠭᠴᠢ [illegible] ᠪᠣᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠷᠤᠭᠳᠠᠬᠤ᠄

᠕.᠑.᠑. [illegible] ᠢ [illegible]᠂
᠕.᠑.᠒. [illegible]᠂
᠕.᠑.᠓. [illegible]᠂
᠕.᠑.᠔. [illegible]᠂
᠕.᠑.᠕. [illegible]᠂
᠕.᠑.᠖. [illegible]᠂
᠕.᠑.᠗. [illegible]᠂
᠕.᠑.᠘. [illegible]᠂
᠕.᠑.᠙. [illegible]᠃

᠕.᠒. ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠥᠯᠦᠭᠡᠯᠡᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠰᠣᠩᠭᠤᠭᠤᠯᠢ ᠳᠤ [illegible] ᠨᠠᠮ᠂ ᠡᠪᠰᠡᠯ [illegible] ᠪᠣᠯ ᠤᠨ ᠬᠠᠮᠠᠷᠤᠭᠳᠠᠬᠤ᠄

᠕.᠒.᠑. [illegible] ᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ [illegible] ᠢ [illegible] ;

᠕.᠒.᠒. [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠢ [illegible] ;

᠕.᠒.᠓. [illegible] ᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ [illegible] ᠳᠤ ᠳᠡᠮᠵᠢᠯᠭᠡ ᠦᠵᠡᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ ;

᠕.᠒.᠔. [illegible] ᠢ [illegible] ;

᠕.᠒.᠕. [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠳᠤ ᠳᠡᠮᠵᠢᠯᠭᠡ ᠦᠵᠡᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ ᠂ [illegible] ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ ;

᠕.᠒.᠖. [illegible] ᠤᠨ [illegible] ᠶᠢᠨ [illegible] ᠳᠤ ᠳᠡᠮᠵᠢᠯᠭᠡ ᠦᠵᠡᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ ;

᠕.᠒.᠗. [illegible] ᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ [illegible] ᠄

᠕.᠓. [illegible] ᠢ [illegible] ᠄

᠕.᠓.᠑. [illegible] ᠂ [illegible] ;

᠕.᠓.᠒. [illegible] ᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ [illegible] ᠂ [illegible] ;

᠕.᠓.᠓. [illegible] ᠂ [illegible] ;

᠕.᠓.᠔. [illegible] ᠂ [illegible] ᠢ [illegible] ;

᠕.᠓.᠕. [illegible] ᠂ [illegible] ;

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible] ᠪᠦᠷᠢᠯᠳᠦᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠄ [illegible]

ᠬᠤᠷᠠᠯ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ᠄ [illegible]

[illegible]

[illegible]

11.1.3. [illegible]

11.1.4. [illegible]

11.1.5. [illegible]

11.1.6. [illegible]

11.1.7. [illegible]

11.1.8. [illegible]

12 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ [illegible]

12.1. [illegible]

12.1.1. [illegible]

12.1.2. [illegible]

᠒᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠳᠠᠭᠠᠯᠳᠠᠭᠤᠯᠬᠤ

᠒᠑.᠑.ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠳᠠᠭᠠᠯᠳᠠᠭᠤᠯᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠪᠠᠶᠢᠩᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ᠂ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ᠂ ᠶᠠᠮᠠᠳ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠡᠷᠬᠡ ᠪᠦᠬᠦᠢ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠃

᠒᠒.᠑.ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠪᠤᠶᠤ ᠭᠠᠷᠭᠠᠭᠰᠠᠨ ᠰᠢᠢᠳᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠨ᠎ᠠ᠃

᠒᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠦᠷ ᠪᠣᠯᠬᠤ

᠒᠓.᠑.ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠳᠠᠭᠠᠯᠳᠤᠭᠤᠯᠤᠨ ᠭᠠᠷᠭᠠᠭᠰᠠᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠦᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠦᠷᠳᠡᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠳ᠋ᠠ.ᠠᠮᠤᠷᠪᠠᠶᠠᠰᠬᠤᠯᠠᠩ

ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠑. ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠵᠥᠪᠯᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ᠂ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦᠷᠢᠮ «ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ» ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠑᠙᠙᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠔ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠠᠷ ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠒. ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠵᠥᠪᠯᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦᠷᠢᠮ «ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ» ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠒᠐᠑᠙ ᠣᠨ ᠤ ᠗᠔ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠠᠷ ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠓. ᠬᠠᠮᠲᠤ ᠬᠠᠮᠲᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦᠷᠢᠮ «ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ» ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠒᠐᠑᠗ ᠣᠨ ᠤ ᠐᠙ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠠᠷ ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠔. ᠰᠠᠶᠢᠳᠤᠭᠤᠳ ᠤᠨ ᠵᠥᠪᠯᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦᠷᠢᠮ «ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ» ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠒᠐᠑᠗ ᠣᠨ ᠤ ᠐᠔ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠠᠷ ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠕. ᠰᠠᠶᠢᠳ ᠤᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠵᠥᠪᠯᠡᠯ ᠦᠨ ᠨᠢᠭᠡ ᠬᠡᠯᠲᠡᠰ ᠦᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦᠷᠢᠮ «ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ» ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠒᠐᠑᠖ ᠣᠨ ᠤ ᠓᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠠᠷ ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠖. ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦᠷᠢᠮ «ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ» ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠒᠐᠑᠖ ᠣᠨ ᠤ ᠓᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠠᠷ ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠗. ᠬᠣᠷᠢᠶᠠᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦᠷᠢᠮ «ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ» ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠒᠐᠑᠖ ᠣᠨ ᠤ ᠓᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠠᠷ ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

᠘. ᠬᠣᠷᠢᠶᠠᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠦᠷᠢᠮ «ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠰᠠᠭᠠᠯᠲᠠ» ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠑᠙᠙᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠠᠷ ᠬᠦᠴᠦᠨᠭᠦᠢ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ᠃

ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠰᠠᠶᠢᠳ᠄

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр | Улаанбаатар хот

## ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.3.28 дахь заалт нэмсүгэй:

“5.3.28.Цагдаагийн хөгжлийн сан.”

**2 дугаар зүйл.**Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Зэвсэгт хүчний хөгжлийн сан,” гэсний дараа “Цагдаагийн хөгжлийн сан,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.1.7 дахь заалт нэмсүгэй:

“22.1.7.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 4.5-д заасан албан тушаалд үүрэг гүйцэтгэх тохиолдолд.”

**2 дугаар зүйл.**Цэргийн албаны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “чөлөөлөгдсөн” гэсний дараа “, Нэгдсэн Үндэстний Байгууллагын энгийн албан тушаалтнаар томилогдсон” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр — Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.5 дахь хэсэг нэмсүгэй:

"4.5.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 4.5-д заасан албан тушаалын үүрэг гүйцэтгэсэн хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцохгүй."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Хууль

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр — Улаанбаатар хот

## ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цагдаагийн албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

**1/“93[1] дүгээр зүйл.Цагдаагийн хөгжлийн сан**

93[1].1.Цагдаагийн хөгжлийн сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1.2, 6.1.3-т зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

93[1].1.1.цагдаагийн баг энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийн Засгийн газраас тогтоосон хэсэг;

93[1].1.2.энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн байгууллагаас ашиглуулж байгаа үндсэн болон туслах зэвсэг, техник, материал хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөхөн төлбөр;

93[1].1.3.энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэлийн нөхөн төлбөр.

93[1].2.Энэ хуулийн 93[1].1-д заасан сангийн хөрөнгийг доор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

93[1].2.1.цагдаагийн байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх;

93[1].2.2.цагдаагийн байгууллагын зэвсэг, техникийг сэргээн сайжруулах, шинэчлэх, сургалтын материаллаг нөөцийг бэхжүүлэх;

93[1].2.3.энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдох бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх.”

**2 дугаар зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийн “1 жил 4 сараар” гэсний дараа “, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн 6 сар тутмыг 8 сараар” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр | Улаанбаатар хот

## ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2010 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 36 | Улаанбаатар хот

## Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр — Дугаар 01 — Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай**

2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр явуулсан Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон дараах нэр бүхий гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй:

1/Жуковын Алдаржавхлан
2/Оюунсайханы Алтангэрэл
3/Норовын Алтанхуяг
4/Наранцэцэгийн Алтаншагай
5/Дашзэгвийн Амарбаясгалан
6/Сайнбуянгийн Амарсайхан
7/Очирбатын Амгаланбаатар
8/Чинбаатарын Анар
9/Аюушийн Ариунзаяа
10/Тилеуханы Аубакир
11/Хүрэлбаатарын Баасанжаргал
12/Цэндийн Баатархүү
13/Мягмарсүрэнгийн Бадамсүрэн
14/Энхтайваны Бат-Амгалан
15/Батын Батбаатар
16/Далайн Батбаяр
17/Ринчиндоржийн Батболд
18/Жигжидийн Батжаргал
19/Дамбын Батлут
20/Отгоншарын Батнайрамдал
21/Жамбын Батсуурь
22/Нацагдоржийн Батсүмбэрэл
23/Халтмаагийн Баттулга
24/Батмөнхийн Батцэцэг
25/Пүрэвийн Батчимэг
26/Энхбаярын Батшугар
27/Бат-Өлзийн Бат-Эрдэнэ

28/Жадамбын Бат-Эрдэнэ
29/Баярмагнайн Баярбаатар
30/Жудагийн Баярмаа
31/Жадамбаагийн Баясгалан
32/Буланы Бейсен
33/Хөххүүгийн Болормаа
34/Энхбатын Болормаа
35/Хүрэлбаатарын Булгантуяа
36/Дуламын Бум-Очир
37/Шинэбаярын Бямбасүрэн
38/Сандагийн Бямбацогт
39/Жанчивын Галбадрах
40/Амгаланбаатарын Ганбаатар
41/Гомбын Ганбаатар
42/Жамбалын Ганбаатар
43/Сайнхүүгийн Ганбаатар
44/Дашдондогийн Ганбат
45/Пүрэвжавын Ганзориг
46/Даваасамбуугийн Ганмаа
47/Лувсаннямын Гантөмөр
48/Хассуурийн Ганхуяг
49/Мөнгөнцогийн Ганхүлэг
50/Цэрэнпилийн Даваасүрэн
51/Гонгорын Дамдинням
52/Тогмидын Доржханд
53/Борхүүгийн Дэлгэрсайхан
54/Болдын Жавхлан
55/Хажекберийн Жангабыл
56/Батбаярын Жаргалан
57/Дамдинсүрэнгийн Жаргалсайхан
58/Сонгобайн Замира
59/Батжаргалын Заяабал
60/Жаргалсайханы Золжаргал
61/Сархадын Зулпхар
62/Цагаанхүүгийн Идэрбат
63/Чулуунбилэгийн Лодойсамбуу
64/Ганзоригийн Лувсанжамц
65/Сүрэнжавын Лүндэг
66/Мэндбаярын Мандхай
67/Лхагвын Мөнхбаатар
68/Цагаанхүүгийн Мөнхбат
69/Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан
70/Тогтмолын Мөнхсайхан
71/Баатаржавын Мөнхсоёл

72/Пүрэвбаатарын Мөнхтулга
73/Цэндсүрэнгийн Мөнхтуяа
74/Загджавын Мэндсайхан
75/Бадрахын Найдалаа
76/Нанзадын Наранбаатар
77/Пүрэвсүрэнгийн Наранбаяр
78/Мөнхтөрийн Нарантуяа-Нара
79/Чинбатын Номин
80/Одсүрэнгийн Номинчимэг
81/Нямтайширын Номтойбаяр
82/Эрдэнэбилэгийн Одбаяр
83/Салдангийн Одонтуяа
84/Ухнаагийн Отгонбаяр
85/Ганбатын Очирбат
86/Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ
87/Бадамдоржийн Пунсалмаа
88/Даваахүүгийн Пүрэвдаваа
89/Бөхчулууны Пүрэвдорж
90/Дүгэрийн Рэгдэл
91/Пүрэвжавын Сайнзориг
92/Цэндийн Сандаг-Очир
93/Отгоны Саранчулуун
94/Мягмардашийн Сарнай
95/Лхагвасүрэнгийн Соронзонболд
96/Ренчинбямбын Сэддорж
97/Цэвэгдоржийн Туваан
98/Буяагийн Тулга
99/Банзрагчийн Түвшин
100/Хишигдэмбэрэлийн Тэмүүжин
101/Ганзоригийн Тэмүүлэн
102/Агваанлувсангийн Ундраа
103/Чинбатын Ундрам
104/Ням-Осорын Учрал
105/Болдын Уянга
106/Гончигдоржийн Уянгахишиг
107/Доржсүрэнгийн Үүрийнтуяа
108/Ганбатын Хосбаяр
109/Бадарчийн Хэрлэн
110/Даваагийн Цогтбаатар
111/Дамдины Цогтбаатар
112/Одонгийн Цогтгэрэл
113/Саруулсайханы Цэнгүүн
114/Жигжидсүрэнгийн Чинбүрэн
115/Баттогтохын Чойжилсүрэн

116/Өлзийхүүгийн Шижир
117/Лувсанцэрэнгийн Энх-Амгалан
118/Баттөмөрийн Энхбаяр
119/Жадамбын Энхбаяр
120/Лутаагийн Энхнасан
121/Доржзовдын Энхтуяа
122/Дашцэрэнгийн Энхтүвшин
123/Мөнхчулууны Энхцэцэг
124/Сүхбаатарын Эрдэнэбат
125/Сүхбаатарын Эрдэнэболд
126/Равжихын Эрдэнэбүрэн

2.Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ Д.РЭГДЭЛ**

# Moehgo& Folo_ oa YekEt Hore& oa Doeedege&

᠒᠐᠒᠔ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠒ - ᠨᠤ ᠡᠳᠦᠷ    ᠳᠤᠭᠠᠷ ᠐᠑    ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠭᠡᠰᠢᠭᠦᠳ ᠦᠨ
ᠪᠦᠷᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠶᠢ ᠬᠦᠯᠢᠶᠡᠨ ᠵᠥᠪᠰᠢᠶᠡᠷᠡᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ

᠒᠐᠒᠔ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠘ - ᠤ ᠡᠳᠦᠷ ᠶᠠᠪᠤᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠡᠭᠡᠯᠵᠢᠲᠦ ᠰᠣᠩᠭᠤᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠳᠦᠩ · ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠨ ᠶᠢᠰᠦᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠒ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ · ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠖·᠒ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ · ᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠗·᠑ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ · ᠑᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠖·᠔·᠑ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠠᠴᠠ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ :

᠑· ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠭᠡᠰᠢᠭᠦᠨ ᠳᠦ ᠰᠣᠩᠭᠤᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠳᠠᠷᠠᠭᠠᠬᠢ ᠢᠷᠭᠡᠳ ᠦᠨ ᠪᠦᠷᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠶᠢ ᠬᠦᠯᠢᠶᠡᠨ ᠵᠥᠪᠰᠢᠶᠡᠷᠡᠭᠰᠦᠭᠡᠢ :

᠑/ [illegible]
᠒/ [illegible]
᠓/ [illegible]
᠔/ [illegible]
᠕/ [illegible]
᠖/ [illegible]
᠗/ [illegible]
᠘/ [illegible]
᠙/ [illegible]
᠑᠐/ [illegible]
᠑᠑/ [illegible]
᠑᠒/ [illegible]
᠑᠓/ [illegible]
᠑᠔/ [illegible]
᠑᠕/ [illegible]
᠑᠖/ [illegible]
᠑᠗/ [illegible]

[illegible]

᠒᠕/ [illegible]
᠒᠖/ [illegible]
᠒᠗/ [illegible]
᠒᠘/ [illegible]
᠒᠙/ [illegible]
᠓᠐/ [illegible]
᠓᠑/ [illegible]
᠓᠒/ [illegible]
᠓᠓/ [illegible]
᠓᠔/ [illegible]
᠓᠕/ [illegible]
᠓᠖/ [illegible]
᠓᠗/ [illegible]
᠓᠘/ [illegible]
᠓᠙/ [illegible]
᠔᠐/ [illegible]
᠔᠑/ [illegible]
᠔᠒/ [illegible]
᠔᠓/ [illegible]
᠔᠔/ [illegible]
᠔᠕/ [illegible]
᠔᠖/ [illegible]
᠔᠗/ [illegible]
᠔᠘/ [illegible]
᠔᠙/ [illegible]
᠕᠐/ [illegible]
᠕᠑/ [illegible]
᠕᠒/ [illegible]
᠕᠓/ [illegible]

᠗᠔/ [illegible]

᠗᠕/ [illegible]

᠗᠖/ [illegible]

᠗᠗/ [illegible]

᠗᠘/ [illegible] — [illegible]

᠗᠙/ [illegible]

᠘᠐/ [illegible]

᠘᠑/ [illegible]

᠘᠒/ [illegible]

᠘᠓/ [illegible]

᠘᠔/ [illegible]

᠘᠕/ [illegible]

᠘᠖/ [illegible]

᠘᠗/ [illegible] — [illegible]

᠘᠘/ [illegible]

᠘᠙/ [illegible]

᠙᠐/ [illegible]

᠙᠑/ [illegible]

᠙᠒/ [illegible]

᠙᠓/ [illegible]

᠙᠔/ [illegible]

᠙᠕/ [illegible]

᠙᠖/ [illegible]

᠙᠗/ [illegible]

᠙᠘/ [illegible]

᠙᠙/ [illegible]

᠑᠐᠐/ [illegible]

᠑᠐᠑/ [illegible]

᠑᠐᠒/ [illegible]

᠑᠐᠓/ [illegible]
᠑᠐᠔/ [illegible]
᠑᠐᠕/ [illegible]
᠑᠐᠖/ [illegible]
᠑᠐᠗/ [illegible]
᠑᠐᠘/ [illegible]
᠑᠐᠙/ [illegible]
᠑᠑᠐/ [illegible]
᠑᠑᠑/ [illegible]
᠑᠑᠒/ [illegible]
᠑᠑᠓/ [illegible]
᠑᠑᠔/ [illegible]
᠑᠑᠕/ [illegible]
᠑᠑᠖/ [illegible]
᠑᠑᠗/ [illegible]
᠑᠑᠘/ [illegible]
᠑᠑᠙/ [illegible]
᠑᠒᠐/ [illegible]
᠑᠒᠑/ [illegible]
᠑᠒᠒/ [illegible]
᠑᠒᠓/ [illegible]
᠑᠒᠔/ [illegible]
᠑᠒᠕/ [illegible]
᠑᠒᠖/ [illegible]

᠒᠂ ᠡᠨᠡ ᠵᠠᠷᠯᠢᠭ ᠢ ᠒᠐᠒᠔ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠒ – ᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠭᠰᠡᠭᠡᠢ᠃

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 16.3.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Дашзэгвийн Амарбаясгаланг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ Д.РЭГДЭЛ**

Moehgol Folo_ oa Yekit Horal oa Doeedegel

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас:8
**Индекс: 200003**